

ЗАВХАН АЙМГИЙН ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН

ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Завхан аймгийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (цаашид Танхим гэх)-ийн гишүүнчлэлийн журам нь гишүүнчлэлийн хүрээнд харилцах харилцааг зохицуулах баримт бичиг юм.
- 1.2. Энэхүү журмын зорилго нь Танхим-д гишүүнээр элсэх, цуцлах, танхимаас авах үйлчилгээний хөнгөлөлт, эрх, үүргээ эдлэх болон үр дүнтэй хамтран ажиллахад оршино.

Хоёр. Гишүүнээр элсэх

- 2.1. Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дүрмийг хүлээн зөвшөөрсөн гишүүн болох хүсэлтэй аж ахуй нэгж, байгууллага, иргэн сайн дурын үндсэн дээр элсэж болно.
- 2.2. Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын гишүүн болох бол доорхи бичиг баримтыг бүрдүүлнэ.
 - А. Анкет бөглөнө./Танхимаас гишүүний анкет авах/
 - Б. Байгууллагын гэрчилгээний хуулга/иргэн иргэний үнэмлэхний хуулбар/
 - В. Байгууллагын танилцуулга
- 2.3. МҮХАҮТ -ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр танхимын гишүүний гэрчилгээг олгоно.
- 2.4. Гишүүнчлэлийн хугацааг гишүүний гэрчилгээ гарсан өдрөөс тооцно
- 2.5. Танхим болон гишүүдийн хүлээсэн үүргийн давуу гишүүний хураамжыг жилд бүр заавал төлнө.
- 2.6. Даргын тушаалаар баталсан гишүүнчлэлийн хураамжыг жил бүр төлнө.
- 2.7. Гишүүн нь Танхимаас үзүүлж буй үйлчилгээнд хөнгөлөлттэй үнээр хамрагдана.

2.8. Танхимын гишүүний хувьд Танхимын үйл ажиллагаанд өөрийн идэвхитэй оролцоогоо бий болгож хамтран ажиллана.

2.9. Танхимд хандсан болон төр, засаг, аймгийн удирдлагуудад хандсан аливаа санал хүсэлт, шүүмжлэлээ бичгээр өгнө.

2.10. Танхимын гишүүн таны хаяг, утас, e-майл өөрчлөгдсөн тухай бүр заавал мэдэгдэнэ.

Гурав. Гишүүнчлэлийн ерөнхий давуу тал ба боломж

3.1. Монголын бизнесийн орчны талаарх мэдээ, мэдээллийг хамгийн түрүүнд авах мөн түүнд оролцох боломж нээгдэнэ.

3.2. МҮХАҮТ болон 20 аймаг дахь салбар танхимууд, сумдад байрлах төлөөлөгчдөөр дамжуулан бизнест ашигтай харилцаа үүсгэх

3.3. МҮХАҮТ -ын гадаад улс орнуудтай тогтоосон харилцаа холбоог ашиглан, төрөл бүрийн төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах, бизнес аялалуудыг хийх боломжтой

3.4. Танхимын гишүүдэд үзүүлдэг аливаа хөнгөлөлтүүдийг эдлэх, бизнес саналууд хамтран ажиллах саналуудыг авах боломжтой.

3.5. Танхимын facebook хуудас болон гаргах брошур танилцуулгуудад өөрийн байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээ, танилцуулгуудаа сурталчилуулах боломжтой.

3.6. Танхимын дэргэд байх салбар зөвлөлүүдэд орж, бизнесдээ байгаа хүндрэл бэрхшээлээ шийдвэрлүүд, бусад байгууллагуудтай хамтран ажиллах боломжтой.

3.7. Танхимын зорилго чиглэлд нийцсэн ажлыг гишүүн санаачлан танхимын нэрэн доор гүйцэтгэх боломжтой.

Дөрөв. Гишүүдийн хариуцлага

4.1. Гишүүд нь бүх гишүүдийн хуралд заавал оролцох бөгөөд хүндэтгэн үзэх шалгаантайгаар хуралд оролцох боломжгүй бол өөрийгөө орлох хүнийг оролцуулна.

4.2. Жилийн гишүүний хураамжаа төлсөн тохиолдолд бүх гишүүдийн хуралд санал өгөх эрхтэйгээр оролцоно.

4.3. Гишүүний хураамж төлсөн тохиолдолд үйлчилгээнд хөнгөлөлт үзүүлнэ.

Тав. Гишүүнээс татгалзах

5.1. Гишүүн нь дүрэмд заасны дагуу 2 жил дараалан гишүүний татвараа төлөөгүй тохиолдолд танхимын гишүүнээс чөлөөлөхөөс 30 хоногийн өмнө бичгээр сануулж чөлөөлнө.

5.2. Гишүүн өөрийн хүсэлтээр танхимын гишүүнээс татгалзаж болно. /Хүсэлт хүлээн авсанаас хойш 5 өдрийн дотор бүртгэлээс хасна/

Зургаа.Гишүүнчлэлийг дахин сэргээх

6.1. Өмнө нь Танхимын гишүүнчлэлээс чөлөөлөгдсөн болон татгалзсан гишүүнийг хүсэлтийн дагуу даргын тушаалаар гишүүнчлэлийн эрхийг дахин сэргээн баталж болно.

6.2. Гишүүнчлэлээ дахин сэргээх хүсэлтэй бизнес эрхлэгчид дараах материалыг бүрдүүлж өгнө.Үүнд

- Байгууллагын гишүүний эрхээ дахин сэргээх тухай өргөдөл
- Анкет бөглөнө./Танхимаас гишүүний анкет авах/
- Байгууллагын гэрчилгээний хуулга/иргэн иргэний үнэмлэхний хуулбар/
- Байгууллагын шинэчилсэн танилцуулга

6.3. Хүсэлт өгсөнөөс хойш ажлын 5 хонгийн доторх гишүүнчлэлээр бүртгэж авна.